



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 2/45

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг  
судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн 3.1 дэх хэсэг, Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод дүрмийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд шалтгааныг тогтоох, судлан бүртгэх, акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга

Гишүүд:

Нисэхийн сургалтын төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багшлагч мэргэжилтэн

Шалгалтын нислэг, зураглалын албаны ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга (харилцан тохиролцсоноор)

Нисэхийн спорт цогцолборын их эмч

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн галын аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

1724 01 0046

2.

2.Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-д заасан комиссын эрх, үүргийг хэрэгжүүлэн тус байгууллагад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, акт дүгнэлтийг Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчаар баталгаажуулах, батлагдсан акт дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл болон цаашид хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сэрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, тухайн алба нэгжид холбогдох шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллахыг комисст даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Комисс томилох тухай” А/149 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хамтын ажиллагааны газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГА



Э.ТӨРБАЯР